

1945 ОНД БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН НИЙТИЙН САНАЛ ХУРААЛТ ЯВАГДСАН НЬ

*Табучи Ёоко**

1945 оны 2-р сарын 11-нд И.Сталин, Америкийн Нэгдсэн Улсын ерөнхийлөгч Ф.Рузвельт, Их Британы ерөнхий сайд У.Черчилль нар холбоотон гүрнүүдтэй Ялтад (Крымд) нууц хэлэлцээр байгуулсан ажээ. Уг хэлэлцээрт ЗХУ фашист Герман улсыг бут цохиод 2-3 сарын дараа Японы эсрэг дайнд оролцохдоо “Гадаад Монгол (БНМАУ)-ын одоогийн байгаа байдал (status quo)-ыг хэвээр байлгах, Японоос 1904 онд итгэлийг эвдэж халдан довтолсноор зөрчигдсөн Орос орны эрхийг сэргээх (зүүн хойт Хятадын боомт, төмөр зам дахь ЗХУ-ын тусгай онцгой эрх зэрэг), Курилын арлуудыг ЗХУ-д шилжүүлэх” зэргийг болзол болгожээ. Үүнд “Гадаад Монголын тухай болон дээр дурдсан боомт, төмөр замын тухай хэлэлцэн тохиролцсон зүйлийг генералиссимус Чан Кайши зөвшөөрсөн байх шаардлагатай” гэж тохиролцсон тул Сталин Японд дайн зарлахаас өмнө Чан Кайшигаар энэ талаар гэрээ байгуулах шаардлагатай болжээ. Ийнхүү Дундад Иргэн Улсыг (ДИУ буюу Чунцингийн засгийн газрыг) Японы дарлалаас чөлөөлөх зорилгоор ЗХУ-аас зэвсэгт хүчний тусламж үзүүлэх тухай Сталин Чан Кайшийн хооронд хэлэлцээр хийхээр болсон байна.

Мөн 6-р сарын 15-нд АНУ-аас ДИУ-д суугаа элчин П.Ж.Харлэй Ялтын хэлэлцээрийн нууц зүйлийг Чан Кайшид албан ёсоор гардуулжээ. Чан Кайши Оуг хэлэлцээрийн агуулгыг мэдмэгц “бачимдан уурласан” тухайгаа өдрийн тэмдэглэлдээ бичиж, уг хэлэлцээрийг “Эх орны (Хятадын) эрх ашигт харшлах нууц хэлэлцээр” буюу Хятад улсаа худалдахыг шаардсан нууц гэрээ) гэж нэрлэжээ.¹

Гэвч тухайн үед Чан Кайшигийн хувьд Хятадын дотоодын дайнаас зайлсхийхийг эн тэргүүнд чухалчлан, урьдаар ДИУ ба ЗХУ-ын харилцааг сайжруулах хэрэгтэй гэж үзэж байв. Юу гэвээс Чан Кайши Сталинтай эвлэрэн гэрээ байгуулах болзол болгож, ЗХУ-аас Хятадын Эв хамт нам болоод Шиньжаан дахь Уйгар үндэсний самуунд зэвсэг нийлүүлэхгүй байх, Японд эзлэгдэж байсан газар нутаг буюу зүүн хойт Хятад болон Өвөр Монголыг Гоминдан намын захиргаанд оруулан нэгдсэн Хятад улсыг байгуулахаар оролдож байлаа.² Иймээс Чан Кайши Японтой хийж буй дайныг дуусгахаас өмнө ДИУ, ЗХУ-тай найрамдлын гэрээ байгуулахыг чухалчилж байсан бөгөөд эцэст нь Ар Монголын

*Табучи Ёоко - Японы Осакагийн Гадаад хэлний их сургууль, доктор (Ph.D)

тусгаар тогтнолын асуудлаар аргагүйн эрхэнд буулт хийсэн ажээ. Тэрхүү буулт нь Ар Монгол дахь Хятадын сюзеренитет эрхийг хүчингүй болгох гэсэн Чан Кайшийн хувьд “асар том золиос” байсан юм.³

1945 оны 8-р сарын 14-нд байгуулсан найрамдалт харилцааны гэрээ бичигт ДИУ-ын ГЯЯ-ны сайд Ван Шицээ, ЗХУ-ын Гадаад хэргийн ардын комиссар В.М.Молотов нар Москвад гарын үсэг зурав. Тэрхүү солилцсон ноот бичигт “Гадаад Монголын ард түмэн тусгаар тогтнох хүсэл эрмэлзлээ байнга илэрхийлсээр байгаа тул Япон улс дайнд ялагдсаны дараа, Гадаад Монголын иргэдийн дунд явуулах санал асуулга энэхүү хүсэл эрмэлзлийг нь нотлон харуулбал Хятадын Засгийн газар Гадаад Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх бөгөөд хил хязгаар нь одоогийн байгаагаар үлдэх болно гэдгийг Хятадын Засгийн газар мэдэгдэж байна” хэмээжээ.⁴ Ийнхүү БНМАУ олон улсын хэмжээнд бүрэн эрхт бие даасан улсын статусаа сая хүлээн зөвшөөрүүлэх нөхцөл бүрдэж, хорьдугаар зууны Монголын тусгаар тогтнолын асуудал шийдвэрлэх шинэ үе шат эхэлсэн билээ.

Эл өгүүлэлд маршал Х.Чойбалсан Монголын тусгаар тогтнолын асуудлаар 1945 оны 10-р сард ДИУ-ын засгийн газрын төлөөлөгч Лэй Фажантай хийсэн хэлэлцээр болоод Монголын ард түмний санал хураалт хэрхэн явагдсан тухай танилцуулахын зэрэгцээ Чойбалсан уг асуудлаар ямар байр суурь баримтлаж байсан тухай авч үзэхийг зорилоо.

1. БНМАУ-д нийтийн санал хураалт явагдсан нь

9-р сарын 25-нд Москвад суугаа элчин Фү Бинчанаас Чүнцин дахь засгийн газарт илгээсэн цахилгаандаа “Чүнцин хот дахь гадаад яамны орлогч сайд танаа толилуулах нь. Саяхан Зөвлөлтийн гадаад яамны орлогч сайд хүлээн авч уулзаад ярилцахдаа Чан Кайши дарга А.А.Петровтой (ЗХУ-аас Чүнцинд суугаа элчин сайд) уулзах үедээ Монголын засгийн газар нэн ойрын хугацаанд бүх нийтийн санал хураалтын ажлыг явуулах нь зүйтэй. Үүний зэрэгцээгээр Хятад улсын засгийн газар төлөөлөгчөө томилон оролцуулах, Монголын засгийн газар мөн нэгэн адил төлөөлөгчөө томилон Хятад улсын баяр ёслолын ажиллагаанд оролцуулах тухай ярилцаж тохиролцсоныг Зөвлөлт улсын засгийн газар Зөвлөлт Улсаас Монгол улсад суудаг албан түшмэлээр дамжуулан Монгол засгийн газарт бичгээр уламжилсныг зарлиг болгосон” хэмээжээ.⁵

Бас уг цахилгаанд Х.Чойбалсан БНМАУ-ын ерөнхий сайд бөгөөд Гадаад яамны сайдын нэрээр ЗХУ-аас Улаанбаатарт суугаа элчинд илгээсэн илэрхийлэл бичгийн хятад орчуулгыг танилцуулсан байжээ. Үүнд

“...Монголын ард түмэн биеэ дааж тусгаар тогтнохын тулд олон жил тэмцэж ирсэн бөгөөд Монголын ард түмний тэмцлийн үр дүнд 1921 онд ардчиллын үндсэн дээр тусгаар тогтносон улсыг байгуулсан юм. Монголын ард түмэн өнгөрсөн 25 жилийн дотор улсынхаа тусгаар тогтнолыг батагтан боловсронгуй болгож ирсэн юм. Монголын ард түмэн эрх чөлөөт улсынхаа дотор ардчилсан үндсэн хуулийн гэрэлт нарны дор эрх чөлөөтэй тусгаар тогтнон аж төрж, энэхүү үндсэн хууль нь Монголыг эрх чөлөөтэйгээр тусгаар тогтнон ажиллах эрх, сурч боловсрох эрх, амрах эрх бусад олон төрлийн ардчилсан эрх чөлөөг хуульчилж өгсөн үүнээс өөр эрмэлзэх зүйл үгүй болно. Монголын ард түмэн хувьсгалт ололтоо хамгаалж капиталист Япон улс Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолд удаа дараалан өнгөлзөхөөр санаархаж байсныг зэвсгийн хүчээр эсэргүүлэн тэмцэж байсны зэрэгцээгээр энэхүү хамгийн сүүлчийн түрэмгийлэгчийг бут ниргэхэд оролцож байсан энэ нөхцөл байдлын дор монголын ард түмнээс тусгаар тогтнох хүсэл эрмэлзэлтэй эсэхийг асуух нь илүүц юм. Энэхүү тусгаар тогтнолыг монголын охид хөвгүүдийн ариун цусаар сольж авсан зүйл. Иймийн тулд БНМАУ 1945 оны 10-р сарын 10-ны өдрөөс 20-ны өдөр хүртэлх хугацаанд бүх нийтийн санал хураалтын ажлыг явуулахаар тогтсон юм. БНМАУ-ын засгийн газар Хятад улсын засгийн газрыг төлөөлөгчөө илгээж бүх нийтийн санал хураалтанд оролцуулахыг зөвшөөрч байгаа болно. 1945-ны 10-р сарын 10-ны өдөр (1911 онд Манж Чин улс мөхөж ДИУ байгуулагдсан өдөр) төлөөлөгчдөө Чүнцин хотноо илгээж санал хураалтын дүнг танилцуулах боломжгүй болсон тул Хятадын засгийн газар хүсвэл БНМАУ-ын төлөөлөгчөөс санал хураалтын дүнг шууд авч болно. БНМАУ энэ оны 11-р сарын эхээр төлөөлөгчөө Чүнцинд илгээж санал хураалтын дүнг танилцуулах болно” хэмээжээ.⁶

Ийнхүү Чойбалсан бүх нийтийн санал хураах улс төрийн чухал ажлын бэлтгэл хийхээр эхлэн ганцхан сарын богино хугацаанд өргөн уудам нутагт тархуу суух малчдын дунд санал хураалтын ажлыг зохион байгуулжээ.

БНМАУ-ын Улсын бага хурал (УБХ)-ын тэргүүлэгчдийн 9-р сарын 21-ний өдрийн 76-р хурлаар “БНМАУ-ын тусгаар тогтнолын талаарх асуудлын талаар бүх ард түмний саналыг гаргуулах тухай” тогтоол баталжээ. Үүнд:

“1. БНМАУ-ын тусгаар тогтносон асуудлын талаар бүх ард түмний санал гаргуулах ажлыг энэ оны 10-р сарын 10-20 хүртэл бэлтгэн явуулсугай.

2. Бүх ард түмний саналыг тус улсын бүх дэвсгэр нутаг дээрээ

10-р сарын 20-ны өдөрт нэгэн зэргээр гаргуулахаар тогтоосугай.

3. Тус улсын сонгуулийн эрх бүхий ард иргэдийг санал гаргах явдалд оролцуулахаар тогтоосугай.

4. Ийнхүү санал гаргуулах ажлыг явуулахдаа тус улсын орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас зохиосон нэрсийн жагсаалтын ёсоор энэхүү санал гаргуулах явдалд оролцох ард иргэдийн саналыг илтэд гаргуулах журмаар гүйцэтгэсүгэй.

5. Тус улсын ард иргэдээс саналаа гаргах явдалд оролцох ба мөн санал гаргагчдын нэрсийн жагсаалтыг зохиохдаа дэвсгэр нутгийн зарчмаар буюу өөрөөр хэлбэл ард иргэн бүрийн байнга оршин сууж буй газраар нь гүйцэтгэхээр тогтоосугай.

6. Ийнхүү санал гаргах явдалд оролцох эрх бүхий бөгөөд жинхэнэ санал гаргах өдөр байнга оршин сууж буй газраа байгаагүй тус улсын ард иргэд бол энэхүү санал гаргуулах өдрөө оршин байсан газраараа саналаа гаргамуй.

7. Ийнхүү санал гаргах явдалд оролцох бүхий боловч, өвчин эмгэг тохиолдсон буюу өтлөж хөгширсөн зэрэг онцгой шалтгаанаар санал гаргах газраа хүрэлцэн ирэх бололцоо үгүй байгаа тус улсын ард иргэд нь тэдний оршин суугаа газартаа хүргүүлсэн нэрсийн жагсаалтад гарын үсгийг зурах журмаар саналаа гаргамуй...

11. Тус улсын ард иргэдийн саналыг гаргуулахдаа бүрэн сайн дурын үндсэн дээр гүйцэтгэх талаар хяналт тавьж байхыг улсын бага хурлын тэргүүлэгчдээс орон нутгийн захиргааны бүх байгууллагуудад сануулж төв комисст даалгасугай..." хэмээжээ.⁷

Санал хураалтын ажлыг удирдуулахын тулд төв комисс байгуулж, даргад Г.Бумцэнд (УБХ-ын тэргүүлэгчдийн дарга), орлогч даргад Ч.Сүрэнжав (МАХН-ын төв хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Мал Аж Ахуйн Яамны сайд), гишүүнд С.Янжмаа, Б.Ширэндэв, Лувсан, Үйлдвэрчдийн төв зөвлөлийн Базарсад, Эвлэлийн төв хорооны Рагчаасүрэн, Монгол Ардын Хувьсгалт Цэргийн Равдан, Хязгаарын цэргийн Санжаа нар ба мөн санал гаргуулах ажлыг эрхлэх аймгийн комиссуудын даргаар аймгийн намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга нарыг тус тус томилжээ.⁸

Мөн хурлаас "БНМАУ-ын тусгаар тогтносон асуудлын талаар бүх ард түмний санал гаргуулах ажлыг явуулах тухай заавар" гаргажээ. Үүнд:

"1. БНМАУ-ын сонгуулийн эрх бүхий бөгөөд 18 насанд хүрсэн тус улсын харьяат эрэгтэй эмэгтэй бүх ард иргэд саналаа гаргамуй. Зөвхөн ухаан солиу хүмүүс үүнд оролцохгүй болой..."

6. Санал гаргах явдлыг доор дурдсан журмаар явуулах. Үүнд баг, хоринуудын сонгогчдын нэрсийн жагсаалтад багтсан ард иргэн бүхэн санал гаргах өдрөө тийнхүү санал гаргах газраа биеэрээ хүрэлцэн ирж өөрийн нэрийн доор “зөвшөөрсөн”, “тагталсан” хэмээх хүснэгтийн нэгэнд гарынхаа үсгийг зурснаар саналаа илэрхийлмүй.

7. Баг, хорины комиссууд нь тийнхүү саналыг гаргуулж дуусмагц уг баг, хорины хэмжээгээр санал гаргуулсан ажлын дүн мэдээг зохиож түүний дотроо саналаа гаргаваас зохих байсан ард иргэдийн тоо ба үүнээс жинхэнэ саналаа гаргасан хүн хэд, саналаа гаргагчдаас “зөвшөөрсөн”, “тагталсан” хэд болохыг тодорхойлон бичсэн байх үүрэг бүхий болно. Энэхүү дүн мэдээ дээр комиссийн бүх гишүүд гарынхаа үсгийг зурсан байваас зохимуй. Эл тодорхойлолтыг зохиомогц түүнийг сонгогчдын гарын үсэг зурсан нэрсийн жагсаалтын хамтаар сум, хорооны комисст нэн даруй хүргүүлвээс зохимуй.

8. Сум хорооны комиссуудын жагсаалт ба тодорхойлолтыг бүх баг, хоринуудаас хүлээн авмагц баг, хорооны тодорхойлолт лугаа ижилхэн хэлбэртэй дүн товчоог сум хорооны хэмжээгээр нэн даруй зохиож, түүн дээрээ сум, хорооны комиссийн дарга ба бүх гишүүдээс гарынхаа үсгийг зураад сум, хорооны захиргааны тамгыг дарж, уул сум, хорооны дүн товчоог баг, хоринуудаас ирсэн бүх материалын хамтаар бие хүнд авахуулан нэн даруй аймаг, хотын захиргаанд хүргүүлмүй. Санал гаргалтын дүн мэдээг багаас сумуудад ба сумуудаас аймгуудад түргэн хүргүүлэхийн тулд сумын захиргаанд нь уул бичиг баримтыг санал гаргасан өдөрт өртөө улаа хэрэглүүлэн хөдөө морьтой бие хүнд авахуулан яаравчлан хүргүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий болно...” гэжээ.⁹

Мөн УБХ-ын тэргүүлэгчдийн 10-р сарын 5-ны өдрийн 85-р хурал санал гаргуулах тухай томъёог тогтоон зарлахдаа “Хэрэв бичиг мэдэхгүй бол баруун гарын эрхий хурууг дар” хэмээн шийджээ.¹⁰

УБХ-ын тогтоол ёсоор төв комиссаас орон нутагт нийтийн санал хураалтын ажлыг удирдаж зохион байгуулахын тулд баг, хорин, хороо, сум, аймаг хотод бүгд 3304 комисс байгуулан, санал хураалтын комиссууд улсын хэмжээгээр иргэдэд санал хураалтын зорилго, саналаа хэрхэн өргөхийг тайлбарлан таниулах ажлыг зохиож, бүх орон даяар хурал цуглаан болж байлаа.¹¹ БНМАУ-ын засгийн газар санал хураалтын ажлыг зохион байгуулах явцад ард олны нэгдэл нягтралыг бат бэх болгож, эх оронч үзэл ба улс төрийн ухамсрыг өндөр болгохоор ухуулга сурталчилгаа явуулж байжээ. 10-р сарын 13-ны өдрийн “Үнэн”

сонинд “Аж үйлдвэрийн комбинатын харьяа, тавдугаар фабрикийн үүрийн тасгийн ажилчин Цэрэндэжид” гэдэг хүний яриа нийтэлжээ. Тэрээр “Би энэ онд гурван удаа их баярлав. Зөвлөлтийн ард түмэн эх орны шударга дайнд Германы фашистуудыг даран сөнөөж, их ялалтын тугийг Берлинд мандуулсан тэр өдөр би тэсгэл үгүй баярлаж байсан билээ. Дорно зүгт шүлс савируулж, гараа сарвалзуулж, манай ах дүү монгол овогтныг дарлан зовоож байсан Японы самурай нарыг манай монголын ард түмэн, түүний ардын хувьсгалт арми, маршал Чойбалсангийн удирдлагын доор ЗХУ-ын улаан армийн хамтаар бүрмөсөн бут цохисон өдөр миний хоёрдахь баярын өдөр минь байв. Одоо улсынхаа тусгаар тогтносон байдлыг дэлхий дахины өмнө үзүүлж эрх чөлөөт монголын түмэн ардын саналыг хураах гэж байгаад гуравдахь баяр минь энэ болох юм.” хэмээжээ.¹²

Ийнхүү 10-р сарын 20-ны өдөр БНМАУ-ын тусгаар тогтнолын тухай ЗХУ, ДИУ-ын засгийн газрын тохиролцсон ёсоор орон даяар бүх нийтийн санал хураах ажил нэгэн зэргээр явагджээ. Мөн өдөрт санал хураалтын ажлыг эрхлэсэн төв комиссийн дарга Бумцэнд радиогоор доорх үг хэлжээ.

“Бүгд Найрамдах Монгол Ард Улсын харьяат эрэгтэй, эмэгтэй, малчин ард, ажилчин ба албан хаагчид, Монгол Ардын Хувьсгалт Армийн бүх байлдагч, офицер, генералууд аа! Өнөөдөр 1945 оны 10-р сарын 20-ны өдөр манай БНМАУ-ын бүх ард түмэн, эрх чөлөөт, тусгаар тогтносон засаг төрдөө хязгааргүй хайртай бөгөөд бат нэгдэлтэйгээ дэлхий дахины өмнө батлан илэрхийлж байна. Манай монголын ард түмний түүх бол эх орныхоо эрх чөлөөт тусгаар тогтносон байдлын төлөө тэмцсэний түүх юм. Манай ард түмний түүхийнхээ турш олон зуун жил тэмцэж ирсэн энэ тэмцэл бол нөхөр Сүхбаатар, Чойбалсангийн удирдлагаар гагцхүү 1921 онд болсон ардын хувьсгалын ялалтын үрээр бүтэж, монгол ард түмэн эрх чөлөөгөө байлдан олж БНМАУ-ыг байгуулсан билээ”.¹³

Мөн өдөр орон даяар нийт ард түмэн баяр наадмын байдалтайгаар санал хураалтанд идэвхтэй оролцжээ. Тухайлбал Увс аймгийн төвд санал хураалтын ажил өглөөний 6 цаг 30 минутад эхэлж 11 цагт дууссан бөгөөд санал хураах байранд дуу концерт, кино гаргасан ба өглөөний 5 цагаас эхлэн цугласан ардууд “хүн бүр гарын үсэг зурахын төлөө гавьшгай өндөр хөдөлгөөнтэй” байсан ажээ. Баянхонгор аймгийн төвд 14 цагт санал хураах ажлыг дууссан ба саналаа өгөх гэж цугласан ардууд арван метр өндөр “Тусгаар тогтнолын

багана”-г босгосон байна. Мөн аймгийнхан “мориньхоо сайхныг унаж, дээлнийхээ сайхныг өмсөн” саналаа өгч, эрийн гурван наадам зохиож бүгдээр маш хөгжилдсэн гэжээ.¹⁴

Нийт дүнгээр санал хураалтад 494960 хүн оролцох ёстойгоос 487409 хүн оролцож, 7551 хүн ямар нэгэн шалтгаанаар санал хураалтад оролцоогүй тул саналаа өгөх бүхий иргэдийн 98.4 хувь нь БНМАУ-ын тусгаар тогтнолыг зөвшөөрөн батласан бөгөөд татгалзсан иргэн нэг ч байсангүй.¹⁵

Зарим түүхчид, жишээлбэл Ж.М.Фритэрс, Сакамото Корэтада, Кашима Акио нар эл санал хураалтын тухайд илээр хураасан ба төрийн албан хаагчийн зааврын дагуу эрхий хуруугаа дарсан бичиг үсэг үл мэдэх хүмүүс 60 шахам хувь байсныг бодоход бүрэн сайн дураараа саналаа өгсөн хэрэг биш, түүний зэрэгцээ өргөн удам нутагт тархуу суух малчдын дунд явуулсан санал хураалтанд саналаа өгөх эрх бүхий иргэдийн 98.4 хувь оролцсон нь итгэшгүй өндөр хувь гэж үзсэн байдаг.¹⁶ Гэтэл илээр санал хураасан эсэх нь Чан Кайшигийн хувьд огтхон ч чухал бус асуудал байжээ. Юу гэвээс урьд ДИУ-ын засгийн газрын төлөөлөгчид Москвад Сталинтай хэлэлцээр хийхдээ ДИУ-ын талаас санал хураалтын талаар ямар болзол шаардлага тавиагүй юм.¹⁷ Чан Кайши буюу ДИУ-ын эрх баригчдын хувьд Ар Монголын тусгаар тогтнолыг аргагүйн эрхэнд хүлээн зөвшөөрөх болсноо хаацайлж, санал хураалтын дунд үндэслэн Хятад дахь үндэсний асуудлыг шийдвэрлэсэн хэмээх байр сууриа илэрхийлэхийн тулд Ар Монголд санал хураалтыг нэн даруй явуулбаас зохино хэмээн шаардсан байдаг. Юутай ч гэсэн 1945 оны 2-р сарын 11-д байгуулсан Ялтын хэлэлцээр болон 8-р сарын 14-нд байгуулсан ДИУ ба ЗХУ-ын хоорондын найрамдалт харилцааны гэрээний дагуу ДИУ нь Ар Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх нь нэгэнт тодорхой хэрэг байжээ.

2. Маршал Чойбалсан ДИУ-ын засгийн газрын төлөөлөгчтэй анх үулзсан нь

9-р сарын 25-нд Чойбалсангийн ард түмний санал хураалтын тухай илэрхийлэл бичгийг хүлээн авсан Чан Кайши, Ар Монгол дахь санал хураалтыг ажиглах төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг томилохын зэрэгцээ ДИУ-ын Гадаад Явдлын Яам (ГЯЯ) болон Улсыг Батлан Хамгаалах Дээд Зөвлөлд (УБХДЗ) БНМАУ-ын засгийн газартай хэрхэн хэлэлцээр явуулах тухай саналаа оруулан хэлэлцүүлжээ. Мөн сарын 28-нд төлөөлөгчдийн тэргүүнээр Дотоод Явдлын Яамны орлогч сайд

Лэй Фажаныг томилохын зэрэгцээ 10-р сарын 1-ий УБХДЗ, Гоминдан Намын Төвийн Гүйцэтгэх Хорооны (ГНТГХ) хамтарсан хурлаар ДИУ-ын төлөөлөгчид Гадаад Монголд байх хугацаанд санал хураалтын үйл ажиллагаанд оролцохгүй байх, зөвхөн Хятад хэлээр ярих, "Гадаад Монгол" хэмээх нэр томьёо хэрэглэх, 11-р сарын эхээр Гадаад Монголын төлөөлөгчдийг Чүнцинд ирүүлэх хүсэлтэй байгааг уламжлахыг үүрэг болгожээ.¹⁸ Лэй Фажан 10-р сарын 8-нд зохих тушаал бүхий 11 хүнийг төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд томилж, улмаар 2 туслах ажилтан, 1 сонин сурвалжлагч оруулан бүгд 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр Бээжингээс Улаанбаатарт онгоцоор нисэх төлөвлөжээ. Гэвч ЗХУ-аас бэлтгэсэн нисэх онгоцонд 15 хүн багтахгүйн улмаас 3 хүн Бээжинд арга буюу үлдэн, 12 хүн ниссэн байна. Мөн сарын 18-нд нисэх онгоцоор Улаанбаатарт хүрэлцэн ирж Нүхтэд байрласан төлөөлөгчид санал хураалтын явцыг ажигласны дараа 24-нд Бээжингээр дамжин Чүнцинд буцжээ.

10-р сарын 18-ны өдөр БНМАУ-ын ГЯЯ-ны орлогч сайд Намсрай, Дотоод Яамны сайд хошууч генерал Шагдаржав, Гадаад Яамны дорно дахины дарга Сэрээтэр нар Улаанбаатарт хүрэлцэн ирсэн Лэй Фажан тэргүүтэй төлөөлөгчдийг нисэх онгоцны буудалт угтан хүлээн авчээ. Нисэх онгоцны буудлыг Монгол, Хятадын далбаагаар чимсэн байжээ.¹⁹

Лэй Фажан Улаанбаатарт долоо хоног байх хугацаандаа 19 болон 23-ны өдөр нийт хоёр удаа маршал Чойбалсантай уулзаж хэлэлцээр хийсэн юм. Бас санал хураалтын ажлыг эрхлэх төв комиссийн дарга Бумцэндтэй 22-ны өдөр нэг удаа, ГЯЯ-ны орлогч сайд Намсрайтай хэд хэдэн удаа уулзаж өдөр тутмын төлөвлөгөөний талаар ярилцаж байжээ. Монгол-хятад хэлний орчуулагчаар БНМАУ-ын талаас С.Ринчинсоном (Өвөр Монголд төрсөн бөгөөд 1920-иод онд Хүрээнд суурьшжээ),²⁰ ДИУ-ын талаас Чү Миншан ба Шау Шахэ (Чойзалжан) нар ажиллажээ. Үүнээс гадна Лэй Фажан ЗХУ-аас Улаанбаатарт суугаа элчин сайд И.А.Ивановтай мөн уулзсан ба энэ үед Оросын мэргэжилтэн Хэ Жижүн орчуулагч хийжээ.

10-р сарын 19-ны өдөр болсон маршал Чойбалсан ба Лэй Фажан нарын анхны уулзалт 16 цагаас 18 цаг 20 минут хүртэл болсон ба үүнд БНМАУ-ын талаас Намсрай, Сүрэнжав, Ринчинсоном нар, ДИУ-ын талаас Чү Миншан, Шау Шахэ, Хэ Жижүн оролцжээ.

Энэхүү уулзалт дээр чухам юу ярилцсан тухай орчуулагч Ринчинсоном монгол хэлээр маш нарийн тодорхой тэмдэглэл хөтөлсөн байдаг. Нөгөөтэйгүүр Лэй Фажан Чүнцин хотод буцсаны дараа Чан

Кайшид өргөсөн илтгэл хуудсанд маш товч, зөвхөн ярианы гол агуулгыг танилцуулсан байдаг. Иймд Ринчинсономын тэмдэглэлээс Чойбалсан ба Лэй Фажангийн ярианы нэг хэсгийг дор танилцуулъя.

Засгийн газрын уулзалт болох өрөөнд Чойбалсан орж ирэхэд харилцан мэндэлсний дараа Лэй Фажан өөрийн дагалдаж яваа хүмүүсийг танилцуулав. Дараагаар Чойбалсан мөн өөрийн дагалдаж яваа хүмүүсийг танилцуулж суулгаахыг урив.

Чойбалсан: Замдаа сайн ирцгээв уу?

Лэй Фажан: Сайн ирцгээлээ.

Чойбалсан: Нисэх онгоцонд бие зайлагдаж ядрав уу?"

Лэй Фажан: Үгүй. Сайн явж ирэв. Зөвлөлтийн хоёр жолооч чадамгай сайн жолоодсон ба агаар улирлын байдал тунгалаг сайн байснаас их сайн явж ирэв.

Чойбалсан: Чүншин бол Улаанбаатраас их хол юмаа. Тиймээс та бүгдийн биед эндхийн цаг агаарын байдал хир зэрэг тохиромжтой байна буй?

Лэй Фажан: Сүүлийн өдрүүдэд агаарын байдал тунгалаг сайн байна. Бид Зүн Шан маягийн хувцас (босоо зах бүхийн дүрэмт хувцас) бүхий ирцгээсэн. Бид өвөл бараан өнгийн хувцас, зун бол бор өнгийн хувцас өмсдөг болно.

Чойбалсан: Танай засгийн газраас та бүхнийг манайд ирүүлснийг ямраар ирүүлсэн гэж би бодох буй?

Лэй Фажан: Засгийн газрын даалгавар бол Монголын засгийн газрын удирдлагатай уулзаад 10-р сарын 10-ны өдрөөс 20-ны өдөр хүртэл тусгаар тогтнолын санал хураах ажил явагдах юм. Ерөөс энэ тухай ажил дэлхий дээрээ алдаршиж байгаа юм. Үүнийг үзээд ирсүтэй хэмээсэн даалгавартай болно.

Чойбалсан: Та нар ирсэн тухай ажлыг мэдэж байна. Энэ тусгаар тогтнолын тухай ажил асуудлыг бид ба дэлхий дахин мэдэж байсан, мэдсээр ч ирсэн юм. Үүнд таныг ойлгоход төлөөлөгч гэж бодох уу, төлөөлөгчид гэж бодох уу?

Лэй Фажан: Төлөөлөгч.

Чойбалсан: Гагц таныг төлөөлөгч гэж ойлгох уу?

Лэй Фажан: Тиймээ. Би гагцаар төлөөлөгч юмаа. Бусдууд нь цөм миний дагалдах ажилчид юм.²¹

Ийнхүү БНМАУ-ын засгийн газрын тэргүүн маршал Чойбалсан ДИУ-ын засгийн газрын төлөөлөгчтэй хийсэн анхны түүхт уулзалт эхэлсэн билээ.

Лэй Фажан үргэлжлүүлэн хэлсэн нь: “Чүнчины засгийн газраас намайг танай улсын тусгаар тогтнолын санал хураах ажлын явцыг үзээд ирсүгэй хэмээсэн. Нөгөө талаар танай улсаас Чүнчинд төлөөлөгч томилж явуулахыг хүссэн болохыг танд уламжилъя. Монголын хөгжил бол сайхан их дэвшилттэй болжээ. Иймд Монголын тусгаар тогтнолыг мөн Чүнчинээс эрмэлзэж байгаа юм. Монгол улс бол их сайхан хөгжжээ. Үүний баримт нь өчигдрийн бидэнд үзүүлсэн киноноос мэдэгдэж байна. Энэ хөгжлүүд бол цөм таны удирдлагын доор олсон хөгжил юм. Монгол орны байдал шинэ барилгатай, өргөн засмал замтай болжээ. Энэ бүхэн цөм таны удирдлагын доор олсон амжилт болно” хэмээн эвсэг үгийг ярихыг оролдож байжээ.

Чойбалсан: Манай улсын хөгжил хэдэн арван жилийн өмнөх байдалтай зэргэцүүлэн бодвоос өнөөдөр танигдашгүй хөгжжээ. Гэхдээ үүнийг Монголын ард түмэн өөрсдөө хийж байгаа болмой. Манай ард түмнээс өөрийн улсыг хөгжүүлэхэд ба мөн тусгаар тогтнох явдалд зүтгэлийг гаргахгүй хүмүүс нэг ч байхгүй. Мөн тусгаар тогтнол, улсын хөгжлийн төлөө ажиллаж, сурах гэх явдалд ард нэг бүр оролцож байна. Таны хэлсэн ёсоор Монгол ард хөгжиж байна гэдгийг би ч мөн тийм юмаа гэж дүүрэн батлаж хэлэх байна.

Лэй Фажан: Танай улс хүчирхэг болох ёстой юм. Хүчирхэг болоход бас нэгдэл хэрэгтэй юмаа. Иймийн учраас би их талархаж байна. Хятад, Монгол хоёрын харилцаа их ойр холбоотой байх ёстой юм. Бидний төлөөлөгчид гарч ирэхэд Хятадын засгийн газрын Чан Кайши тэргүүтнээс хэлсэн нь Монгол ба Дундад улс хоёр их ойрхон харилцаатай байх ёстой юм. Дундад улсаас Монголыг аль болохоор туслан, үгээр дорнод Азийн найрамдлыг буй болгомуй. Энэ бол маш их үүрэг зорилго мөн юм. Тиймийн учраас Хятад, Монгол хоёр найрамдалтай байх ёстой юм.

Чойбалсан: Нэгт айл зэргэлдээ байгаа хоёр улс болбаас эвтэй бол сайн юмаа. Хоёрт найртай бол бүр сайн юм. Иймээс Монгол улс Дундад улсаас эв найрамдалтай байх санал гаргаж байх дор дуртай зөвшөөрмөй. Түүнчлэн дорнод зүгийн улсуудын хоорондоо харилцаатай байх ёстой. Найрамдалтай бол түүний ач холбогдол маш их байна. Үүнийг бид мэдэж байна.

Лэй Фажан: Тэр бол лав тийм байх ёстой юм. Түүхийн үүднээс авч үзсэн ч тийм.

Чойбалсан: Улс байгуулахын нэгэн зорилго бол эв найрамдал хэрэгтэй юм. Эв нэгдэл байваас энэ нь тусгаар тогтнолд ач холбогдолтой юм.²²

Үүнээс үзэхэд ДИУ зэрэг Азийн улсуудтай найрсаг харилцаа тогтоосноор БНМАУ-ын тусгаар тогтнолыг олон улсад хүлээн зөвшөөрүүлэх буюу баталгаажуулах гэсэн Чойбалсангийн байр суурь илэрхий байна. Нөгөө талаар Лэй Фажан илэрхий бөөрөнхийлөн эвсэг үгээр тал засч аль болохоор Чүнцингийн засгийн газрын даалгаврын дагуу Монголын засгийн газрын төлөөлөгчийг Чүнцинд ирүүлэхээр хичээж байсан бололтой. Ийнхүү хоёр этгээд эв найрамдалт харилцааг байгуулахаар тус тусын байр сууриа илэрхийлжээ.

Дараа нь Лэй Фажан маргааш нь буюу 20-ны өдөр болох санал хураалтыг Улаанбаатар хот ба хотоос 20-30 километр зайтай хөдөө очиж ажиглахыг хүсэж байгаагаа уламжилжээ.²³ Лэй Фажан уулзалтан дээр доорх хүсэлт тавьжээ.

“(Монголын) ард түмэн бүхий цөм тусгаар тогтнолоо зөвшөөрсөн нь бидэнд мэдэгдэж байгаа юм. Гэвч хууль ёсны журмаар энэ тухай ажлыг сонирхож үзээд Чүнцингийн Чан Кайшидаа мэдэгдэхийг хүсэж буй хэрэг юм. Асуудал нэгэнт ийм болох тулд Монгол улсаас Чүнцин хотод бидний хамтаар төлөөлөгч очихыг хүсмүй. Чан Кайшигаас Монголын төлөөлөгчийг Чүнцинд очуулахыг танаас хүсэж байсан юмаа”.

Үүний хариуд Чойбалсан: “Та бүхий маргааш нөгөөдөр явах бол та нарын хамтаар явуулж амжихгүй болно. Харин 11-р сарын 12-д Монголын төлөөлөгч ирэхэд зүгээр хэмээсэн сонсгол байсан. Тэр үеэс бол амжина” гэсэнд Лэй Фажанаас:

“Чан Кайшигаас хэлсэн нь та нар ирэхдээ Монголын төлөөлөгчдийн хамт ирвээс сайн байна хэмээсэн. 11-р сарын 12-нд Монголын төлөөлөгчид ирж болно хэмээхийг бид дамжуулъя. Гэвч 11-р сарын 12-ны өдөр бол Хятадын удирдагч Сүн Ятсений төрсөн өдөр юмаа. Тэр өдөрт Монголын төлөөлөгч очих бол мөн сонирхолтой юм. Тийм учраас Монголын төлөөлөгч бидэнтэй хамт яваад Чүнцинд илүү хэд хонохыг хүсмүй” гэжээ.

Үүнд Чойбалсан “сонслоо” хэмээсээр ярианы сэдэв солигдон маргаашийн ажил явдлын тухай ярилцаад уг уулзалт дуусчээ.²⁴

3. Маршал Чойбалсан ДИУ-ын төлөөлөгчдийг хүлээн авсан нь

10-р сарын 23-ны өдөр маршал Чойбалсан Лэй Фажан тэргүүтэй ДИУ-ын төлөөлөгчдийг засгийн газраа хүлээн авч зоог барив. Уг хүлээн авалт 15 цагаас 18 цаг хооронд болсон ба УБХ-ын тэргүүлэгчдийн дарга бөгөөд санал хураалтын ажлыг эрхлэх комиссийн дарга Бумцэнд, ЗХУ-аас Улаанбаатарт суугаа элчин сайд И.А.Иванов, тус элчин сайдын яамны

дипломат ажилтан, БНМАУ-ын засгийн газрын гишүүн болоод шинжлэх ухаан, утга зохиолын зүтгэлтэн нийт дал орчим хүмүүс оролцжээ.

Зоог эхлэх үеэр маршал Чойбалсан, элчин сайд Иванов, төлөөлөгч Лэй Фажан нарыг орж ирэхэд хүлээн авалтын тасалгаанд байсан хүмүүс бүгдээр босч алга ташин “Маршал Чойбалсанд” хэмээн лоозон тавьж ура хашгиран баяр хүргэв.

Чойбалсангаас “Сонсоцгоогтун! Манай их дотнын хань Зөвлөлт Холбоот Улс, түүний олон ард түмнээс Монголын ард түмэнд энэ хорин хэдэн жилийн дотроо үргэлжид сайнаар туслаж ирсэн. Мөн сайн сайхан улс болж байгаа Зөвлөлт Улсын засгийн газар болон ард түмэн, түүний агуу их удирдагч, манай дотнын хань нөхөр Сталины төлөө нэгэн хундагыг өргөө. Хятадын ард түмэн ба түүний засгийн газрын төлөө хундага өргөө. Тус Монгол улс бүрэн эрхт тусгаар тогтнох явдлын тухай санал хураах ажлыг ажиглахаар Хятадын засгийн газраас төлөөлөгдөж ирсэн эрхэм ноён Лэй Фажанаа эрүүл мэндийн төлөө хундага өргөө” гэж үг хэлжээ.²⁵

Чойбалсан урьдаар “манай их дотнын хань Зөвлөлт Холбоот Улс” буюу “манай дотнын хань нөхөр Сталин”-ы төлөө хундага өргөсөн нь ЗХУ, БНМАУ хоёрын бат бэх дотнын харилцааг ДИУ-ын төлөөлөгчдөд зориуд харуулсан мэт. Тэрээр үргэлжлүүлэн “манай дотнын хань хүндэт нөхөр Ивановын мэндийн төлөө” хундага өргөж, үүний хариуд И.А.Иванов “Монголын ард түмний санал сэтгэлийг илэрхийлэгч таны эрүүл мэндийн төлөө” хундага өргөжээ.²⁶

Хүлээн авалтын танхимд Алтанбулаг (Хиагт) дахь Монголын Ардын Түр Засгийн Газрын зураг, Халх голын байлдааны зураг, Сүхбаатарын зураг, Чингис хааны зураг зэрэг Монголын түүхэнд холбогдох зургийг өлгөсөн байсан ба соёл урлагийн тоглолт болж байжээ.

Лэй Фажан Чойбалсангаас зөвшөөрөл авч хэлсэн нь “Ерөнхий сайд, мөн Зөвлөлт Холбоот Улсаас Монголд сууж байгаа элчин Иванов, Гадаад Монголын бүх ноён түшмэдэд илэрхийлэх нь. Өнөөдрийн энэ зочлолд талархаж байна. Монгол, Хятад хоёр бол хэдэн зууны түүхтэй нэгэн гэр бүл мэт байсан. Сүүлийн жилүүдэд Японы эзэрхэг түрэмгий нараас Хятадыг эзлэх байдал тохиолдож, мөн Хятад улс дотооддоо самуунтай байв. Энэ үед Монгол нь зам харилцаагаар хол хөндий байсан. Тиймээс үнэн хэрэг дээрээ тусгаарлаж холбоо харилцаагүй болжээ. Япон улс цагаантны үлдэгдлийг ашиглаж Гадаад Монголыг эзлэх бодлоготой байжээ. Энэ хорь гаруй жилд монголын ард түмэн баатар тэмцлийг хийсний үрээр энэ өдрийн хөгжил дэвшилтийг олжээ. Энэ нь бүх үндэсний

тэмцэл мөн. Монголын энэ тусгаар тогтнолын бүх тэмцэл, амжилттай сайхан хөгжилтүүд нь Чойбалсангийн ач гавьяа мөн тул, одоо Чойбалсангийн эрүүл мэндийн төлөө нэг хундагыг өргөө” хэмээжээ.²⁷

Лэй Фажан хэлж буй “Монгол, Хятад хоёр бол хэдэн зууны түүхтэй нэгэн гэр бүл мэт байсан” буюу ДИУ бол Манж Чин улсыг залгамжилсан улс мөн гэх мэт санаа нь Чүнцингийн засгийн газраас урьдчилан бэлтгэсэн үг байсан бололтой. Мөн “Үнэн” сонины сурвалжлагч Дамдинсүрэнгийн асуултанд Лэй Фажан хариулахдаа “Би Гадаад Монголын эрх баригчид лугаа адилхан баяртай байна. Үүнд энэ удаа Гадаад Монгол ард түмнийхээ саналыг аваад хуулийн ёсоор тусгаар тогтносон байдлыг олжээ. Энэ нь Дундад улсын төрийн бодлого лугаа нийлэлцэв. Учир нь Дундад Иргэн Улсын хувьсгалыг удирдагч Дундад Иргэн Улсын Гоминдан Намын тавьж буй Ардын Гурван Зорилтын доторх ард угсаатны зорилт болбаас даруй гадаадад улс гэрийн тусгаар тогтнохыг эрхэмлэх ба дотоодод олон ард угсаатанд эрх чөлөөт тэгш байдлыг олгохыг бодмуй... (Гадаад Монгол бол) гагцхүү хуулийн ёсоор хэлвээс хэвээрээ Дундад Иргэн Улсын газар шорооны нэгэн хэсэг нь байв. Дундад Иргэн Улс нь бас ч түүний эзэмших эрхийг эдлэв. Даруй 1924 оны Дундад ба Оросын хэлэлцэж тогтоосноор хэлвээс мөнхүү энэ мэт тогтнол баймуй. Гагцхүү энэ зүйлийн байдал төлөв нь яг Гадаад Монголын хууль ёсны суурийн үнэн байдал төлөвтэй харшилджээ” хэмээсэн нь Чүнцингийн засгийн газрын албан ёсны тайлбар бололтой.²⁸ Гэвч энэ нь “Үнэн” сонинд нийтлэгдээгүй юм. Нөгөөтэйгүүр Гоминдан Намын “Төвийн мэдээ” сонины сурвалжлагч Лиү Жэний асуултанд Чойбалсаны хариулсан яриа нь мөн оны 10-р сарын 25-ны өдрийн “Үнэн” сонинд нийтлэгдсэн атал “Төвийн мэдээ” сонинд нийтлэгдсэнгүй ажээ.

Хүлээн авалтын дараа ГЯЯ-ны орлогч сайд Намсрайн өрөөнд Лэй Фажан Чойбалсантай ярилцахдаа “Одоо бид нар ерөнхий сайд танаас эрмэлзэх нь. Гурван сарын өмнө Хятадын засгийн газар ба Зөвлөлтийн засгийн газраас хэлэлцэж тогтоосны ёсоор Гадаад Монголоос төлөөлөгч томилж ард түмний саналыг гаргуулсаны дүнг тодорхойлж явуулахыг биеэр Хятадын засгийн газрын төлөөнөөс илэрхийлмүй. Одоо энэ тухайг ерөнхий сайдаас тодорхойгоор над хэлж өгмүй. Хичнээн хүнийг хэдийд явуулах буй” хэмээжээ.²⁹ Лэй Фажаны хувьд Чүнцингийн засгийн газраас шаардсан даалгаврын дагуу Монголын төлөөлөгчийг Чүнчинд явуулах тухай Чойбалсангаас тодорхой хариу авахыг оролдож байжээ. Үүний хариуд Чойбалсан “Мөн

Монгол улсын засгийн газраас төлөөлөгчөөр хэнийг томилж, түүний хамтаар мөн бусад ажилчид явах болно. Миний санахад долоо буюу найман хүн явах болов уу гэж бодож байна. 11-р сарын шинийн хэддээр болох болов уу гэж бодож байна” хэмээжээ.³⁰

Лэй Фажан “Төлөөлөгч би ба дагалдах ажилчид маргааш маш эрт явахаар шийдвэрлэв. Тус газарт ерөнхий сайд танаас халуунаар зочилсонд талархмуй. Одоогоор танд ангижралыг илэрхийлье. Төлөөлөгч би энэ удаа Улаанбаатарт ирээд аж амьдралын талаар их сайхан тааламжтай байв. Санал сэтгэлийн талаар ч маш сайхан хөгжилтэй байв. Эдгээр бүх зүйлийн сайхан байдлын төлөө ерөнхий сайд танд халуунаар зочилсонд туйлын ихээр хариу талархлыг хүргэе” хэмээснээр хоёр талын уулзалт өндөрлөжээ.³¹

Маргааш буюу 10-р сарын 24-ний өглөө Лэй Фажан тэргүүтэй төлөөлөгчид Бээжингээр дамжин Чүнцинд буцав.

4. Лэй Фажаны зохиосон “Гадаад Монголын нийтийн санал хураалтыг ажигласан тухай илтгэл бичиг”-ээс

Чүнцинд буцсан Лэй Фажан 11-р сарын 3-ны өдрөөр өдөрлөсөн “Гадаад Монголын нийтийн санал хураалтыг ажигласан тухай илтгэл бичиг”-ийг Чан Кайшид өргөжээ. Лэй Фажан Ар Монголд байх хугацаандаа ялангуяа Ар Монгол дахь ЗХУ-ын байр суурь, соёл урлагийн үйл ажиллагаа, нийгмийн эмх журмын талаар анхаарал татсан зүйлийг илтгэсэн байна. Ул илтгэл бичигт Лэй Фажан өөрийн нүдээр үзсэн Ар Монголын байдлын тухай өөрийн бодлоо харьцангуй ил тодорхой нь бичжээ. Уг илтгэл бичгийн агуулгыг товч дурдвал:

Санал хураалтын талаар “Санал хураалтын ажлыг эрхлэх төрийн алба хаагчдын зааврын дагуу нууцаар биш илээр гарын үсэг зурж байсан тулд ардууд өөрсдийнхөө хүсэл эрмэлзлэлийг үнэнчээр илэрхийлж огт чадсангүй” хэмээгээд, хил хязгаарын талаар “Улсын төв музей, сургуулиудтай танилцаж байх үед Монголын газрын зураг өлгөсөн байгааг үзэв. Тэр зураг болон манай улсад хэрэглэж буй зургийн хооронд хил хязгаарын талаар их зөрөөтэй байна”. Урьд нь “төлөөлөгчид Гадаад Монголд байх хугацаандаа санал хураалтын үйл ажиллагаанд оролцохгүй байх, хил хязгаарын асуудлаар үг хэлэхгүй байх ба уг асуудалтай холбогдох баримт бичиг хүлээн авах, гарын үсэг зурахыг хориглоно” хэмээх Чүнцингийн засгийн газрын зааврын дагуу Лэй Фажан нар ямар ч эсэргүүцэл илэрхийлээгүй ажээ.

Нөгөө талаар дипломат ёсны талаар Лэй Фажан “Гадаад Монгол

ба Зөвлөлт Улсын харилцаа маш дотно элэгсэг байна. (Гадаад Монголын засгийн газрын удирдагчид) бидний төлөөлөгчдийг хүндэтгэлтэйгээр ёслон зочилсон боловч тэдний үнэн санаа төдий л ойр бус. Зөвлөлт, Монголын талаас бидэнд дипломат бус явдал гаргасангүй” хэмээгээд Ар Монгол дахь ЗХУ-ын харьяатын талаар “Гадаад Монгол дахь аливаа захиргаанд ЗХУ-ын харьяат тушаалтан ажиллаж байна. Жишээлбэл Чойбалсангийн нэрэмжит их сургуульд ЗХУ-ын харьяат гуч шахам хүн багшилж буй бөгөөд нийт багшийн олонх нь ЗХУ-ын харьяат болно”.

Ар Монголын хөгжлийн талаар “Гадаад Монгол газар нүцгэн, хүн ам ховор байна. ЗХУ-аас хэрэглэгдэхүүний ихэнхийг нь хангадаг. Хүрээний (Улаанбаатар) байдал 20 жилийн өмнөх байдалтай харьцуулбал хөгжсөн нь илэрхий. Гэвч Лүн сум гэх мэтийн хөдөөгийн байдлаас үзвэл маш хоцорч байх бөгөөд Гадаад Монгол дахь хөгжитийн байдал харилцан адилгүй”.

Нийгмийн эмх журмын талаар “Театр, циркд үзсэн жүжигчид уран сайхан тоглох бөгөөд үзэгчдийн эмх журам сайн байсан. Гадаад Монголд зохих хэмжээний Хэвлэлийн газар байгуулагджээ. Ер нь ажилчид маш ажилсаг” гэж үнэлсэн байжээ.³²

5. Төгсгөл

Тухай үеийн Хятадын гадаад дотоодын улс төрийн байдлаас үзвэл 1945 оны 8-р сарын 28-наас 10-р сарын 10-нд Чүнцинд Гоминдан нам ба Хятадын Эв хамт намын удирдлагууд хэлэлцээ хийж, удаан маргалдсаны эцэст “энх тайвнаар улсаа байгуулах үндсэн чиглэл”-ийг баримтлан “энх тайван, ардчилал, бүлгэмдэл, нэгдлийг үндэс болгож дотоодын дайнаас эрс шийдэмгий зайлсхийж, тусгаар тогтносон, эрх чөлөөтэй баян хүчирхэг шинэ Хятад улсыг байгуулах”, Улс Төрийн Зөвлөлдөх Хурлыг хуралдуулах, түүнд улс төрийн олон нам бүлгийг адил тэгш эрхтэйгээр оролцуулахаар тохиролцсон. Гэвч цэрэг, засаг захиргаа зэрэг үндсэн асуудлаар тохиролцоонд хүрч чадаагүй байсан бөгөөд 10-р сарын сүүлчээр Гоминдан нам ба Хятадын Эв хамт намын хоорондын зөрчилдөөний улмаас байдал улам хурцдаж дотоодод иргэний дайн дэгдээх аюултай нөхцөл бий болжээ. Нөгөө талаар 11-р сард Гоминдан намын цэрэг ЗХУ-ын цэргийн хүчээр чөлөөлсөн зүүн хойт Хятад нутгийг нэн даруй захиргаандаа оруулахыг оролдсон боловч энэ нь ЗХУ-ын эрх ашгаас шалтгаалж хялбархан бүтэх асуудал биш гэдэг нь улам бүр тодорхой болжээ. Чан Кайшигийн хувьд Хятад орныг энх тайвнаар нэгтгэж иргэний дайныг зогсоохыг эн тэргүүнд чухалчилж

байсан. Иймээс 1945 оны 8-р сарын 14-нд ДИУ-тай байгуулсан найрамдалт харилцааны гэрээг ЗХУ бодитоор гүйцэтгэх эсэх нь Чан Кайшигийн хувьд амин чухал асуудал байсан тул нэн түрүүнд Ар Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болжээ.

БНМАУ-ын УБХ-ын тэргүүлэгчдийн 1945 оны 11-р сарын 12-ны өдрийн 100-р хурлаар “БНМАУ-ын тусгаар тогтносон асуудлын талаар санал гаргуулсан ажлын дүнгийн тухай” тогтоолыг баталсан ба үүнийг маргааш нь ДИУ ба ЗХУ-ын засгийн газарт тус тус илгээсэн билээ. Уг тогтоол бичигт санал хураалтын дүнгээ тодорхойлохын зэрэгцээгээр “(Санал хураалтын ажлыг эрхэлсэн) төв комиссоос үзэх нь. Санал хураах ажил бол, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ард түмний төрийнхөө тусгаар тогтносны төлөө эрмэлзлэлийг бүрэн баталсан тул энэхүү тусгаар тогтнолыг 1945 оны 8-р сарын 14-ний өдөр ДИУ-ын засгийн газраас илэрхийлсэн ёсоор ДИУ зөвшөөрөн хүлээх ёстой болно” хэмээн илэрхийлжээ.³³

Мөн 11-р сарын 20-нд ДИУ-ын ГЯЯ-ын сайд Ван Шице ЗХУ-ын элчингээр дамжуулан “БНМАУ нь ДИУ-аас тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөгдсөний дараа төлөөлөгчдийг Чүнцинд илгээн гадаад харилцаа тогтоохоор хэлэлцээр хийх болно” хэмээн мэдэгджээ.³⁴ Ийнхүү 11-р сарын 12-нд буюу Сүн Ятсэний төрсөн өдрийн баярын ёслолд Ар Монголын төлөөлөгчийг Чүнцинд ирүүлж санал хураалтын дүнг илтгүүлэх гэсэн Чан Кайшийн хүсэл эрмэлзлэл нь бас л бүтсэнгүй. Нэгэнт дурьдсанчлан 10-р сарын 23-ны өдөр Чойбалсан Лэй Фажанд ярихдаа “Мөн Монгол улсын засгийн газраас төлөөлөгчөөр хэнийг томилж түүний хамтаар мөн бусад ажилчид явах болно. Миний санахад долоо буюу найман хүн явах болов уу гэж бодож байна. 11-р сарын шинийн хэддээр болох болов уу гэж бодож байна” хэмээсэн атлаа төлөөлөгчид явуулалгүй зөвхөн бичиг явуулжээ. ДИУ-ын засгийн газар нэн түрүүнд Ар Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байдалд орсон нь Сталин болоод Чойбалсан хувьд тодорхой болсон байлаа. Иймээс Чан Кайшигийн талаас эсэргүүцэл илэрхийлсэнгүй мэт.

Эцэст нь 1946 оны 1-р сарын 5-ны өдөр ДИУ-ын Дотоод яамнаас илэрхийлэл гаргав. Үүнд “Гадаад Монголын санал хураалтын ажлыг эрхэлсэн комиссийн дарга Бумцэнд танаа, улмаар ноён Чойбалсанд уламжлахыг хүссэнийг толилуулмуу. Одоо улс ардын засгийн газар (Гоминдан засгийн газар) нь Улсыг Батлан Хамгаалах Дээд Зөвлөлийн тогтоолын ёсоор мөн өдрөөс эхлэн Гадаад Монголын тусгаар тогтносныг зөвшөөрснийг илэрхийлэн зарламуй” хэмээсэн бөгөөд энэ тухай нь дараа

өдөр буюу 6-ны Хятадын “Төвийн мэдээ сонин”-д хоёрдугаарт нүүрт арван мөрийн төдий товч мэдээ гарчээ.³⁵

Гоминдан засгийн газар буюу ДИУ-аас БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн атлаа “ Бүгд Найрамдах Монгол Ард Улс” бус “ Гадаад Монгол” хэмээх нэр томъёо хэрэглэсэн нь ДИУ-ын хувьд уг асуудал нь аргагүй эрхэнд хүлээн зөвшөөрсөн гэдгийн гэрч нотолгоо болох мэт.

Мөн 1-р сарын 10-ны өдөр БНМАУ-ын ардын сайд нарын зөвлөл, УБХ-ын тэргүүлэгчид, Монголын Хувьсгалт Намын Төв Хорооны хамтарсан хурлаас тогтоосон нь:

“Монголын ард түмэн, өөрийн эрх чөлөө, тусгаар тогтнолыг олж авахын төлөө олон зуун жилийн турш явуулсан цус урсуулсан хүнд тэмцэл нь бүрэн дүүрэн ялалтад хүрсэн нь. 1921 оны ардын хувьсгалын ачаар олж авсан БНМАУ-ын төрийн тусгаар тогтнолыг зөвшөөрөн хүлээсэн явдлаар илрэн гарч байгаа гэж хангалттайгаар тэмдэглэн үзнэ. Монголын ард түмнээс өөрийн төрийн тусгаар тогтнолыг байлдан олсон явдал бол нийгэм журмын эх орон болсон ЗХУ-ын зүгээс манай ард түмэнд үзүүлсэн ах дүүгийн үнэнч тусламжийн үр дүн бөгөөд мөн Зөвлөлт Улсын үндэс суурийг тавигч Ленин-Сталин нараас Монголын ард түмний төлөө тавьсан эцэг ёсны энхрэл хайрын үр дүн мөн” хэмээжээ.³⁶

Дэлхийн хоёрдугаар дайны дараах Зүүн Ази дах түгшүүртэй байдлын үед Чойбалсан Сталинтай ойр дотнын харилцаагаа чадварлаг ашигласны үр дүнд Чан Кайшигаар БНМАУ-ыг хууль ёсоор тусгаар тогтносон улс мөн хэмээн хүлээн зөвшөөрүүлж чаджээ. 1911 оны цагаагчин гахай жилийн хувьсгалаас хойш Зүүн Азийн олон улсын харилцаа дахь маргаантай асуудал болох Ар Монголын тусгаар тогтнол бол 1946 оны 1-р сарын 5-нд Чан Кайшигийн ДИУ-ын засгийн газраас БНМАУ-ыг хүлээн зөвшөөрснөөр БНМАУ нь сая л хууль ёсоор de jure тусгаар тогтносон юм. Улмаар БНМАУ-ын засгийн газар тусгаар тогтносон бүрэн эрхт байр суурийг олон улсын хэмжээнд бататган бэхжүүлэх зорилгоор 1946 оны 2-р сарын 14-нд ДИУ-тай дипломат харилцаа тогтоосны дараа 6-р сард Нэгдсэн Үндэсний Байгууллагад гишүүнээр элсэх хүсэлтээ анх гаргасан бөгөөд 1961 онд гишүүнээр элссэн билээ.

Монголын нийтийн санал хураалтыг ажиглах Дундад Иргэн Улсын төлөөлөгчдийн бүрэлдэхүүн

	Овог нэр	Албан тушвал
1	Лэй Фажан	Дотоод яамны орлогч сайд
2	Чү Миншан	Монгол төвдийн хэрэг эрхлэх газрын гишүүн ба Монголын асуудлыг эрхлэх хэлтсийн дарга
3	Ма Рүйту	Цэргийн зөвлөлийн дээд зэргийн зөвлөх
4	Жан Гү	Агаарын тээврийн хэрэг эрхлэх улс төрийн газрын хэлтсийн эрхлэгч
5	Лиу Иван	Олон улсын асуудал эрхэлсэн мэргэжилтэн
6	Хэ Жижун	Гадаад яамны хэлтсийн дарга
7	Фү Жүйжин	Дотоод яамны тусгай түшмэл географийн мэргэжилтэн
8	Шүй Жүйжин	Дотоод яамны нарийн бичгийн дарга
9	Лиу Жэн	Төвийн мэдээ сонин сурвалжлагч
10	Шай Шахэ (Чойзалжан)	Монгол хэлний орчуулагч
11	Лу Сижун	Эмч
12	Чэн Динчэн	Туслах ажилтан

Ашигласан материал: Academia Historica, Го мин жэн фу дан ан, “Вай мэн гүн мин туу фиао юу бай мэн дү ли”, Лэй Фажан “Гадаад Монголын нийтийн санал хураалтыг ажигласан тухай илтгэл бичиг” 22-р тал.

Улаанбаатар хотод айлчилсан Дундад Иргэн Улсын төлөөлөгчдийн өдөр тутмын тэмдэглэл (1945 он)

сар	өдөр	цаг	
10	9		Чунцин хотоос нисэх онгоцоор Бээжин хотод буув.
	18	8:00 13:00 15:00 19:00	Бээжин хотоос нисэв. Улаанбаатар хотод буув. Гадаад яамны орлогч сайд Намсрайн хүлээн авалтад оролцов. Кино үзэв. (22:00 хүртэл)
	19	10:00 13:00 16:00 21:00	Гадаад яамны орлогч сайд Намсрайтай хэлэлцээр хийв. ЭХУЛ аас суугаа элчин сайд И. А. Ивановтай уулзав. Маршал Х. Чойбалсантай хэлэлцээр хийв. (18:20 хүртэл) Улсын төв театрт концерт үзэв. (24:00 хүртэл)
	20	21:00	Санал хураалтыг ажиглав. Улсын цирк үзэв. (24:00 хүртэл)
	21	13:00 21:00	Түүхийн музей ба Шашны музей үзэв. (16:00 хүртэл) Улсын төв театрт “ Шарай голын гурван хаан ” жүжиг үзэв. (шөнийн 1:00 хүртэл)
	22	9:00 18:00	Төв хорооны сургууль, Улсын дээд сургуультай танилцав.(13:00 хүртэл) Санал Хураалтын Төв Комиссийн дарга Г.Бумцэндтэй хэлэлцээр хийв.
	23	9:00 16:00	Улсын их сургууль, Улсын хэвлэх газартай танилцав. (13:00 хүртэл) Маршал Х.Чойбалсангийн хүлээн авалтад оролцов. Дараа нь Чойбалсантай хэлэлцээр хийв.
	24	8:40 12:40	Улаанбаатар хотоос нисэв. Бээжин хотод буув.
11	1		Чунцин хотод буув.

Ашигласан материал: Academia Historica, Го мин жэн фу дан ан, “Вай мэн гүн мин туу фиао юу бай мэн дү ли”, Лэй Фажан “Гадаад Монголын нийтийн санал хураалтыг ажигласан тухай илтгэл бичиг” 16-17-р тал. “Үнэн” сонин, 1945 оны 10-р сарын 22-ны өдрийн дугаар.

**Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нийтийн
санал хураалтын дүн**

		Санал өгсөн хүний тоо	Гарын үсэг зурсан (үсэг мэдлэг) хүний хувь
1	Сэлэнгэ аймаг	11,979	45.5%
2	Булган аймаг	21,857	71.8%
3	Төв аймаг	36,425	97.6%
4	Дорноговь аймаг	12,868	49.6%
5	Хөвсгөл аймаг	36,304	44.5%
6	Сүхбаатар аймаг	17,370	53.5%
7	Чойбалсан аймаг	19,781	56.4%
8	Өмнөговь аймаг	12,303	45.0%
9	Архангай аймаг	35,587	43.3%
10	Баянхонгор аймаг	24,117	35.1%
11	Өвөрхангай аймаг	30,134	23.9%
12	Дундговь аймаг	15,485	51.2%
13	Хэнтий аймаг	22,664	53.1%
14	Увс аймаг	25,788	28.4%
15	Ховд аймаг	21,848	32.5%
16	Баян-Өлгий аймаг	17,438	38.0%
17	Завхан аймаг	35,651	32.8%
18	Говь-Алтай аймаг	19,820	35.0%
19	Улаанбаатар хот	24,846	91.7%
20	МАХН-ын цэрэг	35,608	99.2%
21	Дотоод яам	9,141	98.9%
22	ЗХУ-д буй	395	-
	Дүн	487,409	(дунджаар) 53.7%
Санал хураалтанд оролцоогүй хүний тоо 7,551			

Ашигласан материал Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Архив
(МАХНТА) ф.2.д.12.хн.272.43-р тал.

МАХНТА ф.4.Д.12.хн.275.150-р тал

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. “Зун тун чан гүн да ши чан биэн чү гау” (Чан Кайшигийн өдрийн тэмдэглэл) 5-р доод боть, Тайбэй, 1978 он, 726-р тал. Табүчи Ёоко “1945 оны монголын тусгаар тогтнолын асуудал ба Чан Кайши /Монголын ард түмний санал хураалтын өмнөх түүхэн нөхцөл/”, Олон Улс Судлал, Улаанбаатар, 2005 он, № 2, 112-120-р талд өгүүлсэн буй.
2. Мөн 732-р тал.
3. Мөн 747-р тал.
4. М.Батчимэг эмх. “Орос-Хятадын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхтгэл, нэгдүгээр хэсэг 1689-1949” Улаанбаатар, 2001 он, 208-р тал.
5. Academia Historica, Го мин жэн фу дан ан “Мэн чи жэн чин (Монгол хошуунуудын улс төрийн байдал)”, No.0591.30-4408.01-01, 1945 он 9-р сарын 19-ны өдөр, Москвад суугаа ДИУ-ын элчин Фү Бинчангаас ДИУ-ын ГЯЯ-д явуулсан бичиг. /Чан Дажун. “Вай мэн шэн дай ши (Гадаад Монголын орчин үеийн түүх)”, 4-р боть, Тайбэй, 1983 он, 1525-1526-р талд буй хэсгийг монголчилсон Г.Гунгаа “Хятад, Оросын харилцааны түүхэн дэх Монгол улс” Улаанбаатар, 1995 он, 83-84-р талаас авав/
6. Мөн тэнд.
7. “Үнэн” сонин, 1945 он 10-р сарын 3-ны өдрийн дугаар.
8. Мөн тэнд.
9. Мөн тэнд.
10. “Үнэн” сонин, 1945 он 10-р сарын 9-ны өдрийн дугаар.
11. “Улаан Од” сонин, 1945 он 11-р сарын 15-ны өдрийн дугаар.
12. “Үнэн” сонин, 1945 он 10-р сарын 13-ны өдрийн дугаар.
13. “Үнэн” сонин, 1945 он 10-р сарын 22-ны өдрийн дугаар.
14. Мөн тэнд.
15. “Улаан Од” сонин, 1945 оны 11-р сарын 15-ны өдрийн дугаар.
16. Gerard.M.Friters “Outer Mongolia and Its International Position” New York, 1974, p.212. Сакамото Корэтада “Хэнкио о мэргүрү чүсо канкэйши”, Хятад, Орсын хил хязгаарын харилцааны түүх, Ажиа кэизай кэнкиүшо, Япон, 1974 он, 85-р тал. Кашима Акио “Чиүсо гайкоши кэнкиү 1937-1949”, Хятад, Оросын гадаад харилцааны түүхийн судалгаа, Сэкайшисосиа, Япон, 1990 он, 199-200-р тал.
17. Табүчи Ёоко “1945 оны Монголын тусгаар тогтнолын асуудал ба Чан Кайши /Монголын ард түмний санал хураалтын өмнөх түүхэн нөхцөл /”-д өгүүлсэн буй.
18. Academia Historica, Го мин жэн фу дан ан, “мэн чи жэн чин” 1945 он 9-р сарын 28-ний өдөр, Улсыг Батлан Хамгаалах Дээд Зөвлөлд (УБХДЗ)-ын нарийн бичгийн дарга Ван Чухуйгаас Чан Кайшид явуулсан бичиг. Мөн 1945 он 10-р сарын 1-ний өдөр, УБХДЗ, Гоминдан Намын Төвийн Гүйцэтгэх Хорооны (ГНТГХ)

- хамтарсан хурал. Мөн 1945 он 10-р сарын 8-ны өдөр, Дотоод яамны орлогч сайд Лэй Фажангаас Чан Кайшид явуулсан бичиг. Мөн 1945 он 10-р сарын 16-ны өдөр, Ван Чухуйгаас Чан Кайши болон Лэй Фажанд явуулсан бичиг
19. “Үнэн” сонин, 1945 оны 10-р сарын 19-ны өдрийн дугаар
 20. Табүчи Ёоко, “Монгору жин гайкоккан эринчинсунуму номита 1946 нэн 2 гацу но чиугуку”, 1946 оны 2-р сарын Хятадын тухай Монголын дипломат ажилтан С.Ринчинсоном тэмдэглэсэн нь), Ex Oriente, Осакагийн Гадаад Хэлний Их Сургууль, No.8, Япон, 2003 он, 159-182-р талд өгүүлсэн буй.
 21. Монгол Улсын Үндэсний Төв Архив (МУҮТА) ф.11, д.1, хн.881, 26-27-р тал.
 22. Мөн 27-28-р тал.
 23. 1945 оны 10-сарын 20-ны өдөр Лэй Фажан, Чү Миншан, Ма Рүйту, Жан Пу, Шүй Жүйжин, Лиү Жэн нар Улаанбаатар хотод, Хэ Жижүн, Лиү Иван, Фү Жүйжин, Шау Шахэ, Лү Сижүн, Чэн Динчэн нар Төв аймгийн Лүн суманд очиж санал хураалтыг ажиглажээ. Academia Historica, Го мин жэн фу дан ан, “Вай мэн гүн мин туу фиао юу бай мэн дү ли (Гадаад Монголын нийтийн санал хураалт болон Гадаад Монголын тусгаар тогтнол)” No.0590.02-2344.01-01, Лэй Фажан “Гадаад Монголын нийтийн санал хураалтыг ажигласан тухай илтгэл бичиг” 17-18-р тал.
 24. МУҮТА ф.11, д.1, хн.881, 33-34-р тал.
 25. Мөн 46-47-р тал.
 26. Мөн 47-48-р тал.
 27. Мөн 48-49-р тал.
 28. Мөн 73-76-р тал.
 29. Мөн 52-р тал.
 30. Мөн 52-р тал.
 31. Мөн 52-53-р тал.
 32. Academia Historica, Го мин жэн фу дан ан, “Вай мэн гүн мин туу фиао юу бай мэн дү ли” Лэй Фажан “Гадаад Монголын нийтийн санал хураалтыг ажигласан тухай илтгэл бичиг” 12-21-р тал.
 33. “Улаан Од” сонин, 1945 он 11-р сарын 15-ны өдрийн дугаар.
 34. Дундад Иргэн Улсын Гадаад Яамны Архив, Яа ши су, “Юу гүан су лиан вай мэн жи ши лиао” No.62-102, 1-3-р тал.
 35. Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Архив, ф.4, д.13, хн.97, 14-р тал. “Төвийн мэдээ” сонин, Чүнцин хот, 1946 он 1-р сарын 6-ны өдрийн дугаар.
 36. “Үнэн” сонин, 1946 он 1-р сарын 11-ний өдрийн дугаар.